

Батлав: БОУАӨЯ-ны Хүрээлэн буй
орчны, бодлогын хэрэгжилтийн газрын
дарга

_____ Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Хангад Эксплорэйшн” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

_____ Д.Энхбат



БАРУУН НАРАН ТӨСӨЛ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН “БАРУУН НАРАН” ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-014493
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2887134

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын ахлах шинжээч _____ Ц.Жаргалнэмэх

Боловсруулсан:

“Хангад эксплорэйшн” ХХК-ийн Байгаль орчны ахлах менежер _____ П. Батболд П.Батболд

2026 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1. Баруун наран уурхайн үйл ажиллагаа.....	1
1.2. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчин ба нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	3
2. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2
2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	3
2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	3
2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	3
2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	4
3. БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ	4
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	5
4.1 Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ.....	5
4.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	5
4.3 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	6
4.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	6
5.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	7
6.ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
7.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
8.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
9.ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ.....	10
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	11
10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим.....	12
10.2 Хог хаягдлыг зайлуулах, устгах арга зам	Error! Bookmark not defined.
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	15
12.1 Газрын доорхи усны хяналт шинжилгээ.....	15
12.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	16
12.3 Хөрсний судалгаа	17
12.4 Ургамал, Амьтны аймгийн судалгаа.....	18
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	19
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	20

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баруун нарангийн чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутагт аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 61 км, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 орчим км зайнд оршдог ба 4485.64 га талбайд ашигт малтмал ашиглах MV-014493 тоот тусгай зөвшөөрлийн лицензийг Хангад Эксплорейшн компани эзэмшдэг. Хангад Эксплорейшн ХХК-ийн Баруун наран нүүрсний уурхай нь Монголын Уул Уурхайн Корпораци \ Энержи Ресурс ХХК\ бүрэлдэхүүн хэсэг юм. Баруун наран уурхайг 2012 оны 1 сард улсын комисст хүлээлгэн өгч улмаар нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн. Баруун наран уурхайгаас Ухаа худаг уурхай хүртэлх нүүрс тээврийн хатуу хучилттай зам тавьж 2012 оны 11 сард улсын комисст хүлээлгэн өгсөн. Ингэснээр нүүрс тээвэрлэлтийн явцад үүсэх тоос шороо, хөрс, ургамал талхлагдах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулснаас гадна тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж чадсан. Баруун наран уурхайгаас 2026 оны уулын ажлын төлөвлөлтөөр 4.79 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн координат:

- | | |
|------------------------|-------------------------|
| 1. 105°10'0" 43°38'00" | 2. 105°16'00" 43°38'00" |
| 3. 105°10'0" 43°37'00" | 4. 105°16'00" 43°35'00" |
| 5. 105°13'0" 43°37'00" | 6. 105°13'00" 43°35'00" |
| 7. 105°13'0" 43°38'00" | 8. 105°13'00" 43°34'00" |

1.1. Баруун наран уурхайн үйл ажиллагаа

Барууннаран ордын үндсэн 2 давхраас болох Н болон Т дээр тулгуурлан зүүн, баруун гэсэн 2 уурхайг үүсгэж зэрэг олборлолт явуулахаар уурхайн төлөвлөлтийг хийсэн байна.

Баруун наран уурхайгаас төлөвлөгөөт онд 40,148 сая.м³ уулын цул үүнээс 4,793 сая.тн нүүрс олборлож, 3,108 сая.м³ хөрс хуулж, хөрс хуулалтын дундаж коэффициент 7.8 м³/тн ашиглалтын төлөвлөж байна.

Барууннаран ордын баруун уурхайд “ЮУ ЭЙ АР ПИ” ХХК, зүүн уурхайд “Эс ЖиКоул Майнинг” ХХК тус тус гэрээт олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. 2026 онд нэмэлтээр Стандарт девелопмент групп” ХХК нь 5 экскаватор, 45 дамп трак, туслах техникүүдийг нэмж ажиллуулахаар төлөвлөж байна. Мөн ажилчдын тоо нэмэгдэх тул уурхайн талбайд түр ашиглах оффис, хурлын заалыг байгуулна. Ордын уул-геологийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг уурхайн мөргөцөгөөс нүүрсний агуулах хүртэл, агуулахаас Ухаа худагийн баяжуулах үйлдвэр хүртэл тус тус тээвэрлэнэ. Олборлосон нүүрсийг уурхайн түр агуулахаас Ухаа худаг хүртэл тээвэрлэхдээ 31.6км зайд тусгайлан бэлдсэн хатуу хучилттай замыг ашиглана.




Зураг 1. Уурхайн захиргааны байр ба засварын төв

Уурхайн тосгон нь ордоос хойд зүгт 6 км зайд байрладаг. Тосгонд ажилчдын байр, гал тогоо хоолны заал, халуун усны газар, уурын зуух, материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байна.

Зам усалгаа ба ногоон байгууламжийн усалгаанд уурхайгаас гарах шүүрлийн усыг ашиглана. Ундны болон ахуйн зориулалттай усыг уурхай ба тосгон дээр байрлах өрөмдмөл 4 гүнийн худгаас хангадаг болно. 2020 онд Баруун наран уурхайн Цахилгааны төв шугамтай холбогдсоноор цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах боломжтой болсон.

Уурхайн түлшний хэрэглээг уурхайн талбайд байрлах 50м³х8 нөөцлүүр бүхий шатахуун түгээх станцаас хангана.




Зураг 2. Уурхай ба уурхайн тосгон



Зураг 3. Уурхайн шатахуун түгээх станц



Зураг 4. Уурхайн талбайд байрлах “Эс ЖиКоул Майнинг” ХХК-ийн оффис болон засварын төв



Зураг 5. Уурхайн талбайд байрлах ЮУ ЭЙ АР ПИ ХХК-ийн оффис болон засварын төв
Нүүрс тээвэрлэлтийн авто зам

Баруун наран нүүрсний уурхай нь Гашуунсухайт боомт хүртэл хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдсон. Барууннаран уурхайгаас “Ухаа худаг”-ийн уурхай хүртэл 31.6 км хатуу хучилттай авто замыг 2013 онд байгуулж, ашиглалтад оруулсан. Баруун наран уурхайгаас Ухаа худаг хүртэлх 1.97 км тээврийн замыг 2024 онд Ухаа худаг уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан тэлэлттэй холбоотойгор шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.



Зураг 6. Баруун наран уурхайгаас Ухаах удаг нүүрс уурхай хүртэлх авто зам

1.2. Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчин ба нийгэм эдийн засгийн төлөв байдал

1.2.1. Баруун наран уурхай орчмын хөрсний хэв шинжийн онцлог

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс ухаа гүвээ толгодод хамрагдана. Хөрсний хээрийн судалгаа ба лабароторийн шинжилгээний үр дүнд үндэслэж доор дурьдсан хөрсний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйлийг тогтоосон. Үүнд:

- Нам уулс, ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн үүрмэг чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн нугархаг хөрс
- Гуу жалга сайрын хөрс

;lmx

1.2.2. Уур амьсгалын тойм

Даланзадгад хотын сүүлийн 10 жилийн агаарын температурын мэдээнээс харахад жилийн агаарын дундаж температур нь 5.8°C байна. Цогтцэций сумын жилийн агаарын дундаж температур 4.3°C байдаг байна. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь -12.9 - -13.7°C , хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь $+23.1$ - $+24.5^{\circ}\text{C}$ байдаг байна. Уур амьсгалын дулаарлаас болж жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа,

хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч дулааны нөөц нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Төсөл хэрэгжих Баруун Нарангийн уурхай нь харьцангуй нам дор, өргөн уудам хөндийд, алсуураа говийн уулс, нам толгод, гүвээгээр хүрээлэгдэн орших ба жилийн ихэнх хугацаанд буюу дунджаар 210 орчим хоног дулаан байдаг байна.

Энэ бүс нутагт жилдээ 104.3 мм орчим хур тунадас унадаг. Хур тунадасны хэмжээ жилийн дотор нилээд өөрчлөлттэй хуваарилагддаг буюу 4-10 дугаар саруудад жилийн нийт хур тунадасны 68-93% нь унадаг боловч зөвхөн 7-8 дугаар саруудад 60-70% орчим нь унадаг байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч гол төлөв хүчтэй аадар борооны тоо олшрох болсон.

Жилийн дундаж салхины хурд 2.4-5.1 м/сек ба сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/сек хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт хаврын улиралд салхины хурд харьцангуй их буюу 4.3-5.1 м/сек хурдтай байдаг. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой.

Агаарын харьцангуй чийгшлийн их утга нь өвлийн саруудад ажиглагдах бөгөөд 1 ба 12 дугаар саруудад 50-68% байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана.

1.2.3. Ургамалан нөмрөг, түүний онцлог

Оорцогийн хоолой буюу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 20 овог, 46 төрөлд хамаарах 70 зүйл ургамал бүртгэгдсэн. Зүйлийн тоог нийт 4485,64 га талбайн хүрээнд харьцуулбал ургамлын янз зүйл 0.01 буюу төдийлэн баялаг биш ч тухайн говь цөлийн нөхцөлд байх ёстой хэмжээндээ байгаа юм. Овгуудын дотор хамгийн олон зүйлтэй нь Луулийн овог 11 зүйлтэй, Нийлмэл цэцэгтний овог 10 зүйлтэй, Үетний ба Буурцагт ургамлын овог тус бүр 5 зүйлтэй, бусад нь 1-2 зүйлтэй. Зүйлийн бүрдэлд унаган ургамлын тоо 9, Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйл 3 байна. Түүнчлэн зүйлүүдийн дотор 10 зүйл сөөг, 14 зүйл заримдаг сөөг, 1 зүйл сөөгөнцөр, 7 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд бусад 28 зүйл ургамал нь олон наст өвслөг ургамал юм.

1.2.4. Амьтны аймаг, түүний онцлог

Төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүслүүрт хамрагдаж байгаа бөгөөд Монгол орны хөхтөн амьтдын газар зүйн мужлалаар Дорнод говийн мужид хамрагдаж байгаа юм. Бүс нутгийн ургамлан нөмрөгийг шүтэн өөхөн сүүлт атигдахай, таван хуруут атигдахай, соотон алагдаага, элсч савагдаахай, зэгэл алаг дааганцар, монгол даахай, бүрдийн шишүүхэй, орог зусаг, хадны барагчин, түвд ов, шар чичүүл, дагуур огдой зэрэг мэрэгчид байх ба түүгээр хооллодог маануул мий, саарал чоно, хярс үнэг, шар үнэг, өмхий хүрэн зэрэг амьтад байхаас гадна хулан адуу, янгир ямаа, хар сүүлт, аргаль хонь, цагаан зээр зэрэг салаа битүү туурайтан амьтад идээшилж бэлчээрлэдэг.

Баруун нарангийн талбайн хэмжээнд 6 багийн 35 зүйл хөхтөн амьтад тэмдэглэгдсэн байна. Эдгээрээс шилүүс, цоохондой, чоно, үнэг, хулан, янгир, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг том хөхтөн амьтад нь ихэвчлэн хайгуулын талбайн баруун урд талаар орших уулс тэдгээрийн хооронд хөндийгөөр тохиолдоно. Харин талбай дотор ихэвчлэн жижиг мэрэгчид тархсан байдаг.

Суурь судалгааны хугацаанд 32 зүйл шувуу хайгуулын талбай болон орчмын бүсэд тэмдэглэгдсэн байна.

1.2.5 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Барууннарангийн нүүрсний уурхайн тусгай зөвшөөрлийн талбай нь Ханхонгор сумын Хондот багийн нутаг дэвсгэрт байрладаг байна. Ханхонгор сум нь Улаанбаатар хотоос 532 км, аймгийн төвөөс 25 км зайд байрладаг бөгөөд өөрийн аймгийн 8 сумтай хиллэдэг. Өмнөговь аймгийн Ханхонгор сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Богд хан уул аймгийн Дэлгэрхангай уулын

хошуу. Судалгааны бүс болох Ханхонгор сум 2015 оны байдлаар нийт 722 өрхтэй байсан бол 2022 онд энэхүү тоо 829 болж 107 өрхөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3-1. Ханхонгор сумын хүн ам, өрхийн тоо

Сумын нэр	2015		2020		2022	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Ханхонгор	722	2025	800	1981	829	1989

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өмнөговь аймгийн Ханхонгор сум нь 2022 оны байдлаар нийт хүн амын тоо 1989, үүнээс эрэгтэй 1079, эмэгтэй 910 хүн оршин сууж байна. Өмнөговь аймгийн Ханхонгор сум нь Мандах, Өгөөмөр, Хондот, Жаргалант гэсэн нийт 4 багтай. Багийн түвшинд хүн амын өсөлтийг 2022 оныг 2015 онтой харьцуулсан байдлаар авч үзвэл Хондот, Жаргалант багийн хүн ам буурсан үзүүлэлттэй байгаа бол Мандах болон Өгөөмөр багийн хүн ам багахан хувиар өсжээ.

Хүснэгт 3-2. Хүн амын жилийн дундаж өсөлт, багаар

№	Баг, хороо	2015	2022	Жилийн дундаж өсөлт (2022 оныг 2015 харьцуулсан дүн)
1	1-р баг, Мандах	393	413	0.64
2	2-р баг, Өгөөмөр	677	689	0.22
3	3-р баг, Хондот	424	381	-1.27
4	4-р баг, Жаргалант	531	506	-0.59
	Ханхонгор сум нийт	2025	1989	-0.22

Хүн амын нягтаршил улсын хэмжээнд 1 километр квадрат газар нутагт 2.1 хүн оногдож байгаа бол Өмнөговь аймгийн үзүүлэлт 0.4 хүн байна. Харин Ханхонгор сумын хүн амын нягтралын хувьд 1 километр квадрат газар нутагт 0.2 хүн оногдож байна.

1. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баруун наран уурхайгаас нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлох, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт тоосонцорын хэмжээ ихсэх
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан
- Галлагаа, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Нүүрс ачиж буулгах талбай дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалснаас нүүрс өөрөө халж шатсанаас хүлэмжийн хий ялгарах
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт бодис материал ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кэмпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх

2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Нүүрс тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

2. БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Өмнөговь аймгийн Ханхонгор суманд орших Баруун нарангийн ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримталсан. Хангад Эксплорейшн ХХК-иас Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх Баруун нарангийн уурхайгаас нүүрс олборлох, тээвэрлэх төслийн байгаль орчны менежментийн гол зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байрлах Загт товогт заг тарих
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ зохион байгуулах

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2026 онд нийт 108.13 сая төгрөг шаардагдах бөгөөд Хангад Эксплорейшн ХХК байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан.

Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан зардал нь байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилан тодорхойлогдох боломжтой хэсэг бөгөөд шууд гүйцэтгэлээр тодорхойлогдох, үйлдвэрлэлийн зардлаар хийгдэх зарим ажлуудын зардлыг энд оруулаагүй болно.

Баруун наран төслийг хэрэгжүүлэгч Хангад Эксплорейшн ХХК 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулан ажиллана.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Уурхайн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян,төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	2	3	4	5	6	7	8	9
4.1 Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ								
1.	Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг услах	Ил уурхай	м³/сар	Үйлдвэр-лэлийн зардлаас Үйлдвэр лэлийн зардлаас	500	Үйлдвэр-лэлийн зардлаас Үйлдвэр-лэлийн зардлаас	Уурхайн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байх үед	Агаарын тухай хууль,
2.	Уурхайн технологийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, замын арчилгааг хийж үүсэх тоосыг бага байлгах	Ил уурхайн	км/цаг		50			Агаарын тухай хууль,
3.	Ухаа худаг уурхайгаас Баруун нарн чиглэл нүүрс тээврийг цахилгаан хөдөлгүүртэй хүнд даацын автомашинаар гүйцэтгэх	Ил уурхайн	ш		10			Агаарын тухай хууль,
4.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
4.	Уст цэгт хамгаалах, сайжруулж сэргээх ажил зохион байгуулах	Уурхай орчмын уст цэг	ш	3,790.0	2	7,580.0	Жилд 1 удаа	Усны тухай хууль
5.	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах,	Хангад эксплорэйшн ХХК	ш	Үйл ажиллагааны зардлас	1	Үйл ажиллагааны зардлаас	1-р улиралд	Усны тухай хууль
6.	Цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулж, горимын	Ажилчдын кемп	ш	Үйлдвэр	1	Үйлдвэр	1-12 сар	MNS4943:2015

	дагуу ажиллуулж саарал усыг дахин ашиглах;			-лэлийн зардлаас		-лэлийн зардлаас		
7.	Богвойн шанд малчдын гар худаг болон уст цэгийг цэвэрлэх	Уурхай орчмын уст цэгүүд	ш	600.0	1	600.0	6-р сард	
4.3 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
8.	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих	Ил уурхай	м ³	Үйлдвэрлэлийн зардлаас	-	Үйлдвэрлэлийн зардлаас	Шимт хөрсний хуулалт ба хадгалалт стандарт хангасан байх	MNS 5916:2008
9.	Нүүрс тээврийн автомашинуудад хучлага ашиглах	Нүүрс тээврийн үйл ажиллагаа	-		-		Бүх автомашинийг хучлагатай явуулах	Газрын тухай хууль
10.	Нүүрс тээврийн дагуу хог хаягдлын цэвэрлэгээг зохион байгуулах	Нүүрс тээврийн үйл ажиллагаа	Сар бүр	Үйлдвэрлэлийн зардлаас	12	Үйлдвэрлэлийн зардлаас	1-12 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
11.	Шимт хөрсний овоолгын хөрсөнд цацраг идэвхийн шинжилгээ хийлгэх	Ил уурхай	ш	50.0	4	200.0	Жилд 1 удаа	MNS 5916:2008
4.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
12.	Уурхай болон оффис орчмын ногоон байгууламжийн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах	Ил уурхай	8938ш мод	500.0	6	3,000.0	5-10 сар	
13.	Ухаа худагаас Баруун наран явах цахилгаан шугамын дагуу шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт явуулах,	Цахилгааны шугам сүлжээний дагуу	-	1,000.0	-	1,000.0	Жилд 1 удаа	Амьтны тухай хууль

14.	Уурхайн ахилт тэлэлтийн талбайд ховор ургамлын судалгаа хийлгэх	Ил уурхай	1 удаа	5,000.0	-	5,000.0	Жилд 1 удаа	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр
Нийт						16,380.0		

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян,төг	Нийт зардал, мян,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлж хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байрлах Загт товогт заг тарих	ш	5000	5.0	25,000.0	4-10 сар хүртэл	Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг , Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
3.	“Хашааны эрүүл ахуй тав тухтай орчин бүрдүүлэх”	Ханхонгор сумын хашаатай айл өрхөд тарьц суулгац олгож амьдарч буй орчноо ногооруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	ш	700	5.5	3,850.0	5 ба 10-р сард	
Нийт					28,850.0			

5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын суурь судалгааны үр дүн ба Өмнөговь аймгийн БОАЖГ-с өгсөн чиглэлд үндэслэн 2018 оноос хойш Ханхонгор сумын Хондот багийн нутаг болох Их ууланд уулын туруутан амьтдын популяцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 онд Их ууланд зэрлэг амьтдад зориулан автомат ажиллагаатай уст цэг байгуулсан.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Их уул орчмын уулын туруутан амьтдыг хамгаалах	Уулын туруутан амьтдад зориулан хаврын улиралд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Их уул	1	2,600.0	2,600.0	Жилд 1 удаа	Амьтны тухай хууль
2.		Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг ажиллуулах	Их уул	1	3,000.0	3,000.0	Жилд 1 удаа	Амьтны тухай хууль
3	Зэрлэг амьтдыг хууль бус ангаас хамгаалах	Хууль бус ан, тэдгээрийн гаралтай эд, эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх” төсөлд дэмжлэг үзүүлэх	Өмнөговь аймгийн Ханхонгор сум	1	5,000.0	5,000.0	5,000.0	5-р сар
Нийт					10,600.0			

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компани нь 2012 оноос эхлэн төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт айлыг нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгосон бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд жил бүр өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	-	Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	Нөлөөллийн бүсийн айл өрх	2300 боодол өвс	Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас		Өвс тэжээлийг зорилтот өрхүүдэд өгсөн байх	Ашигт малтмалын тухай хууль

7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компани нь 2012 оноос хойш холбогдох хууль ба компанийн нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлсэн бөгөөд холбогдох хуулийн дагуу төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө археологи, палентлогийн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулсан.

2026 онд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Соёлын биет бус өв	Тэмээчдийн мэдлэг, баярын уламжлалыг хойч үед нь өвлүүлэх Тэмээний баяр болон торомны уралдаанд зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх	Ханхонгор сумын Хондот багийн Тэмээний баяр	-	Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас		Жилд 1 удаа	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.		Монгол өв соёл, эрийн 3 наадам ёс заншлыг ажиллагсаддаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хадгалж үлдэхэд хувь нэмрээ оруулах.	Ханхонгор сумын наадам	-	Компанийн нийгмийн хариуцлагын зардлаас		7 сард	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ажиллагсдын мэдлэг дутуугаас аюул эрсдэлд өртөх	Уурхайн ажиллагсдыг аюулгүй ажиллагаа, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах	Уурхайн хэмжээнд	1	500.0		2-р улиралд	ХАБЭА тухай хууль Гамшгаас хамгаалах хууль
2.	Галын аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ мэдлэг дутуугаас үүсэх эрсдэл	Гамшгаас урьдчилан сэргийлэх практик сургалтад хамруулах	Баруун наран уурхай	1	1,500.0			Гамшгаас хамгаалах тухай хууль
3.	Галын хорны бэлэн байдал хангагдаагүйгээс аюул эрсдэл үүсэх	Галын хорны үзлэг шалгалтыг сар бүр хийх	Баруун наран уурхай	12	Үйл ажиллагааны зардлаас		Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
4.	Болзошгүй осол эрсдэл	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээллэх	Нийт ажилчдад	Сар бүр	500.0		Сар бүр	
5.	Шатахууны агуулахын ёмкость бүрэн бүтэн байдал алдагдаж, асгарах, цоорох,уурших, гал түймрийн аюул үүсэх, дэлбэрэх	ШТС-ын шугам хоолой, резервуар, арматур, холбоо суудын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах	ШТС	Сар бүр	500.0		Сар бүр	MNS 4628:2013 шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага
Нийт					3,000.0			

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Энгийн хог хаягдал	Уурхай орчмын зам талбайд цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхай орчим	-	500.0	4	2,000.0	Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
2.		Хаягдал дугуйг эрх бүхий байгууллагад шилжүүлэх	Засварын төв	м³	500.0	2	1,000.0	Улирал тутам	
3.		Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	м³	-	2	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	
4.	Аюултай хог хаягдал	Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Засварын төвүүд	тн	-	10	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	
5.		Аюултай хог хаягдлын цэгт хөмсөг болон дээвэр хийх	Засварын төвүүд	м²	10,600.0	1	10,600.0	1-р улиралд	
		Е- Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр хийх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийх	Гэрээт компаниуд	Удаа	1,000.0	1	1,000.0	1-12 сард	
6.		Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх	Засварын төвүүд	Улиралд 1 удаа	2,000	4	8,000	Улирал тутам	
Нийт					21,600.0				

10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Баруун наран төслийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.



Зураг 10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Түүнчлэн хог хаягдлын менежментийн 5R (Refuse–Reduce–Reuse–Recycle–Recovery) зарчмыг үйл ажиллагааны чиглэл бүрээс үүсэх хаягдалд хамааруулан баримтлахыг зорьж байгаа ба энэхүү зарчим нь уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн хариуцлагатай болгох нэгдсэн тогтолцоо юм.

5R хог хаягдлын нэгдсэн тогтолцооны хүрээнд бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: химийн бодисын хэрэглээг хамгийн бага түвшинд бууруулах, чанарын үзүүлэлт харилцан адилгүй нүүрсийг хооронд нь холих зарчмаар чанарын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, говийн нөхцөлд усны ашиглалтыг оновчтой зохицуулан хамгийн бага хэмжээнд барих, уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хаягдал дугуйг замын хамгаалалт болон дуу чимээ тусгаарлагч болгон ашиглах, хаягдал мод, төмрөөр дахивар бүтээгдэхүүн хийж хэрэглэх, дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж эрх бүхий байгууллагад шилжүүлэн дахин боловсруулалтад оруулах, мөн хоол үйлдвэрлэлээс гарах органик хог хаягдлыг ялзмагжуулан бордоо болгох арга замыг эрэлхийлэн хэрэгжүүлж байна.

10.2. Хог хаягдлын урсгал ба зохицуулалт

Хэсэг нэгжийн үйл ажиллагааны онцлогоос хамааран энгийн ба аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дэд төрлүүдэд ангилан ялгана. Дэд төрлүүдэд багтсан хог хаягдал тус бүрийг өнгөний код бүхий хогийн сав болон тохирох хаяг шошготой тусгай талбайд ангилан цуглуулна. Цуглуулсан хаягдлыг хуулийн шаардлагад нийцүүлэн дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, хуулийн хугацаанд түр хадгалах, зарим сав баглаа боодол болон цэнэглэх боломжтой хаягдлыг нийлүүлэгчид буцаах, хоолны хаягдлаар бордоо хийх гэх зэргээр зохицуулагдаж байна

№	Хогийн савны өнгөний код	Хаягдлын төрлүүд
1.		Ахуйн хог хаягдал
2.		Хуванцар сав, зөөлөн гялгар уут, зөөлөн хуванцар
3.		Тосоор бохирдсон хаягдал, хаягдал тос, тослох материал, химийн бодисын хаягдал, түүний сав, баглаа боодол

10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	6	7
1.	Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх	1,000.0	Уурхайн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байх үед	Байгаль орчны хэсэг	Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирвол илэрвэл залруулах
2.	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	4,000.0		Гэрээт гүйцэтгэгч компани	Бүх нийтээр түгээмэл тэмдэглэдэг 3 доошгүй өдрүүд
3.	Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих	-	Тухай бүр	Дэд бүтцийн алба	Сар бүр төлбөрийг төлж барагдуулах
4.	Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хүргүүлэх	1,000.0	Төлөвлөгөөт онд	Байгаль орчны хэсэг	Байгаль орчны хууль эрх зүйн төлөвлөгөөт 2025 оны аудит
5.	Идэвхитэн байгаль хамгаалагчийн ажилд дэмжлэг үзүүлэх	5,000.0	Төлөвлөгөөт онд	Гэрээт гүйцэтгэгч компани	Их болон бага уулын 2 идэвхитэн байгаль хамгаалагч
Нийт		11,000.0			

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

12.1 Газрын доорхи усны хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Гар худгуудын усны түвшин	Уурхай орчимд байрлах малчдын 3 гар худаг	Сард 1 удаа	12	800.0		3 гар малчдын худаг	-
2.	Малчдын гар худгуудын усны чанарын хяналт.	Уурхай орчимд байрлах малчдын 3 гар худаг	Жилд нэг удаа	1	500.0		3 гар малчдын худаг	MNS 900: 2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3.	Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээ хийлгэх	Кемп болон уурхайн 4 цэгт	Жилд нэг удаа	1	300,0		4	MNS 900: 2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт				1,600.0				

12.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Уурхайгаас үүсэх нарийн ширхэгт тоосыг хянах зорилгоор РМ 2.5 хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлох	Уурхай орчимд байрлах 3 цэг 24 цагаар хэмжих	Сар бүр	12		900.0	3 цэг	MNS4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага
2.	Гадаад орчны агаарын чанарын \ NO ₂ , SO ₂ , хэмжилт хийх	Баруун, Зүүн уурхайн пит, Ажилчдын хотхон ШТС, Доод тээврийн зам дагуу, Байгалийн фон	Жилд 1 удаа	1		1.800.0	6 цэг	MNS4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага
Нийт				2.700.0				

12.3 Хөрсний судалгаа

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Баруун наран уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх	Баруун, зүүн уурхайг засварын төв 3, ШТС, Аюултай хог хаягдлын цэг Кемпийн хогийн цэг, Кемпийн авто зогсоол орчим, Байгалийн фон цэг	Жилд нэг удаа	1	400.0		8 цэг	MNS 5850: 2019 Хөрс бохирдуулагч элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	Хөрсний агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолгууд	Жилд 1 удаа	1	300.0		4 цэг	БОНБУт хууль
Нийт				700.0				

12.4 Ургамал, Амьтны аймгийн судалгаа

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ургамлын аймгийн судалгаа хийх	Төслийн талбай	Жилд 1 удаа	1	7,000.0		6 цэг	БОНБҮТ ХУУЛЬ
2.	Амьтны судалгаа хийлгэх	Их уул, Бага уул	Жилд 1 удаа	1	-			БОНБҮТ ХУУЛЬ
Нийт								
ОХШХ-н нийт зардал, мян.төг				12,000.0				

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Хондот багийн мод тарьсан иргэд	Ярилцлага	Туршлага судлуулах аялал зохион байгуулах	Жилд 1 удаа	2,500.0	Байгаль орчны хэсэг	Ханхонгор сумын Хондот баг
2.	Ханхонгор сумын иргэд	Ярилцлага	Хамтын оролцоотой мониторинг	Жилд 1 удаа	1,500.0	Уурхайн удирдлага Байгаль орчны хэсэг Орон нутгийн харилцааны нэгж	Ханхонгор сумын Хондот баг
3.	Ханхонгор сумын иргэд	Багийн иргэдийн хуралд	Компанийн үйл ажиллагааны, байгаль орчны гүйцэтгэлийн талаарх мэдээлэл	Жилд 1 удаа	300.0	Уурхайн удирдлага Байгаль орчны хэсэг Орон нутгийн харилцааны нэгж	Баруун наран уурхай
4.	Ханхонгор сумын ЗДТГ-т	Бичгээр	Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тооллого хийх	Жилд 1 удаа	400.0	Байгаль орчны хэсэг	Баруун наран уурхай
Нийт				4,700.0			

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгийн 50 хувийг “Хангад эксплорэйшн” компаниас Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсвийн төрөл	Төлөвлөсөн төсөв сая.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба бууруулах арга хэмжээ	16.38
2	Нөхөн сэргээлт	28.85
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10.6
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	Үйл ажиллагааны зардлаас
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-
6	Осол эрсдэлийн менежмент	3
7	Хог хаягдлын менежмент	21.6
8	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	11
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	4.7
Нийт		108.13